



Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны 09 дүгээр сарын 07.-ны өдрийн А/135 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН
ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ
БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРГАЛТЫН
БАЙГУУЛЛАГЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

НЭГ. Зорилго

1.1. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 17¹ дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийг ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх журам”-ыг тус тус үндэслэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах сургалтын байгууллага (Цаашид “Сургалтын байгууллага” гэх)-ыг сонгон шалгаруулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хүртээмжтэй, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчим баримталж зохион байгуулна.

ХОЁР. Хамрах хүрээ

Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, шалгаруулалтад оролцох сургалтын байгууллагад тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, сургалтын байгууллагуудыг үнэлэх зэрэг үйл ажиллагааг хамаарна.

ГУРАВ. Хамаарах талууд

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг (дүүрэг)-ийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, Сургалтын байгууллагууд.

ДӨРӨВ. Баримт бичгийн хариуцагч

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилт, судалгааны газар.



ТАВ. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах

5.1. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан Ажлын хэсэг сургалтын байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулна.

5.2. Ажлын хэсэг нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдсэн 9-11 хүний бүрэлдэхүүнтэй байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд мэргэжлийн хяналт болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн төлөөлөл оролцоно.

5.3. Ажлын хэсэг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын шийдвэрээр байгуулсны дараа сонгон шалгаруулалт явуулах зарыг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн албан ёсны цахим хуудас болон олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сонгон шалгаруулалт эхлэхээс 30 хоногийн өмнө зарлан мэдээлсэн байна.

5.4. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нар сургалтын байгууллагуудын баримт бичгийг зарласан хугацаанд хүлээн авсан он, сар, өдөр, хүлээлгэн өгсөн хүний гарын үсгийг зурж баталгаажуулан хүлээн авч, ирүүлсэн дарааллын дагуу жагсаалт үйлдэн, битүүмжилсэн хэвээр нь Ажлын хэсэгт хүлээлгэн өгнө.

5.5. Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын нээлтийг зөвхөн тогтоосон газар, товлосон хугацаанд зохион байгуулна.


5.6. Ажлын хэсгийн гишүүд нь сонгон шалгаруулалтыг дараах дарааллаар явуулна. Үүнд:

5.6.1. Сонгон шалгаруулалтад оролцох сургалтын байгууллагын төлөөллийг оролцуулан ирүүлсэн баримт бичгийн жагсаалтад бүртгэгдсэн дарааллаар битүүмжлэлийг нээж, сонгон шалгаруулалтын баримт бичиг бүрэн, зохих журмын дагуу үйлдсэн эсэхийг шалгаж, шаардлага хангасан баримт бичгийг бүртгэн авч, бүрдэл дутуу баримт бичгийг холбогдох сургалтын байгууллагад мэдэгдэнэ.

5.6.2. Ирүүлсэн баримт бичиг бүртэй танилцаж, сонгон шалгаруулалтад орох сургалтын байгууллагад тавигдах шаардлага, үнэлэх аргачлалын дагуу үнэлгээ өгнө.

5.6.3. Сургалтын байгууллага нь сонгон шалгаруулалтын нээлтийн товлосон хугацаанаас өмнө баримт бичгийг буцаан авах тухай хүсэлтээ албан бичгээр ирүүлсэн тохиолдолд баримт бичгийг буцаан олгоно. Харин сонгон шалгаруулалтын нээлтийн үед хүсэлт ирүүлсэн тохиолдолд баримт бичгийг буцаан олгохгүй.

5.6.4. Сонгон шалгаруулалтын нээлтийн үед хөтөлсөн тэмдэглэлд Ажлын хэсгийн гишүүд болон нээхэд байлцсан оролцогчид бүгд гарын үсэг зурж





баталгаажуулна. Оролцогчид гарын үсэг зурахгүй байх нь сонгон шалгаруулалтын нээлт хүчингүй болох үндэслэл болохгүй.

5.6.5. Сонгон шалгаруулалтад оролцох сургалтын байгууллагын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж болно.

5.6.6. Энэ журмын 8 дахь хэсэгт заасан “Үнэлэх аргачлал”-ын дагуу сонгон шалгаруулалтыг ажлын 10 өдөрт багтаан зохион байгуулж, дүгнэлт гарган Ажлын хэсгийн дарга, гишүүд гарын үсэг зурж, баталгаажуулна.

5.6.7. Сонгон шалгаруулалтын эцсийн шийдвэр гарах хүртэл хугацаанд баримт бичгийг хянан үзэх, тодруулах, үнэлэх болон гэрээ байгуулах эрх олгох тухай дүгнэлттэй холбоотой аливаа мэдээллийг энэ үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй этгээдэд мэдээлэхийг хориглоно.

5.6.8. Сонгон шалгаруулалтын дүн, танилцуулгыг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргад хүргүүлэн холбогдох шийдвэр гаргуулна.

5.6.9. Сонгон шалгаруулалтын дүнг шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн албан ёсны цахим хуудсанд байршуулж, нийтэд мэдээлнэ.

5.7. Ажлын хэсэг нь сургалтын байгууллагыг сонгон шалгаруулж, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын шийдвэр гарсны дараа холбогдох баримт бичгийг архивын нэгж болгон архивт хүлээлгэн өгснөөр сонгон шалгаруулах үйл ажиллагаа дуусгавар болно.

5.8. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар нь сургалтын байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг жил бүр зохион байгуулах бөгөөд сонгон шалгаруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг тухай бүр шинэчлэн батална.

5.9. Сонгон шалгаруулалтад ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нар саналын эрхгүйгээр оролцоно.


ЗУРГАА. Сургалтын байгууллагад тавигдах шаардлага

6.1. Сонгон шалгаруулалтад “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалт зохион байгуулах” эрхийн гэрчилгээтэй сургалтын байгууллага оролцоно.

6.2. Сургалтын байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

6.2.1. Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/33 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, шалгалт авах журам”-ын 2.1-д заасан шаардлагыг хангасан байх;

6.2.2. Сүүлийн 2 жилийн хугацаанд сургалтын тогтмол үйл ажиллагаа явуулсан байх;





6.2.3. Нийгмийн даатгалд шимтгэл төлөгчөөр бүртгэгдсэн, ажилтнуудаа нийгмийн даатгалд бүрэн хамруулсан, шимтгэлийн өр, төлбөргүй байх;

6.2.4. Сүүлийн 3 жилд Мэргэжлийн хяналтын болон холбогдох байгууллагуудаас хийсэн хяналт шалгалтаар зөрчил дутагдал гаргаагүй байх, гаргасан тохиолдолд зөрчил дутагдлыг арилгаж, актаар тогтоосон төлбөрийг хугацаанд нь бүрэн барагдуулсан байх;

6.2.5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж, хүргүүлсэн байх;

6.2.6. Сургалтад оролцогчдоос сэтгэл ханамжийн судалгаа авч дүгнэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан байх.

6.3. Сүүлийн 2 жилд Эрүүл, мэнд, нийгмийн даатгалын хэлтэстэй гэрээ байгуулан сургалт зохион байгуулсан бол тухайн хэлстийн сургалтын үр дүнг үнэлсэн үнэлгээ, дүгнэлтийг ирүүлнэ.

6.4. Сургалт зохион байгуулах эрхийн гэрчилгээний хугацаа дууссан бөгөөд гэрчилгээгээ сунгуулах хүсэлтээ шалгаруулалт явуулахаас 30 хоногийн өмнө гаргаагүй бол шалгаруулалтад оруулахгүй.

ДОЛОО. Бүрдүүлэх баримт бичиг

7.1. Сургалтын байгууллага нь дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

7.1.1. Сонгон шалгаруулалтад оролцох тухай хүсэлт;

7.1.2. Төрийн болон төрийн бус байгууллагын өмчийн хэлбэрийг тодорхойлсон баримт бичиг;

7.1.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах эрхийн гэрчилгээний хуулбар;

7.1.4. Зориулалтын стандартын шаардлага хангасан өөрийн сургалтын анги танхимтайг нотлох үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар;


7.1.5. Зориулалтын стандартын шаардлага хангасан түрээсийн сургалтын анги танхим түрээсэлсэн түрээсийн гэрээний хуулбар;

7.1.6. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тухайн жилийн сонгон шалгаруулалт зарласны өмнөх сарын тайлан (НД№ 7, 8)-гийн хуулбар;

7.1.7. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын болон Хувь хүний орлогын албан татварын сонгон шалгаруулалт зарласны өмнөх улирлын тайлангийн хуулбар;

7.1.8. Энэхүү журмын 6.2.2-т заасан хугацаанд гэрээгээр сургалт зохион байгуулсан бол хамтран ажилласан харьяалах Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн тодорхойлолт;

7.1.9. Сургалт зохион байгуулсан аймаг, дүүрэг тус бүрийн Мэргэжлийн хяналтын болон холбогдох байгууллагуудаас хийсэн хяналт шалгалтаар





зөрчил дутагдал гаргаагүй, гаргасан тохиолдолд төлбөрийг бүрэн барагдуулсан талаарх тодорхойлолт;

7.1.10. Өмнөх онд зохион байгуулсан сургалтын сэдвийн жагсаалт, товч тайлан;

7.1.11. Өмнөх онд зохион байгуулсан сургалтад оролцогчдоос авсан сэтгэл ханамжийн судалгаа, түүнд хийсэн дүгнэлт;

7.1.12. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төвөөс тухайн сургалтын байгууллагыг сонгон шалгаруулалтад оролцуулахыг дэмжсэн тодорхойлолт (гэрчилгээний хугацаа хүчинтэй эсэх, гэрчилгээний хугацаа дууссан тохиолдолд хүсэлт гаргасан эсэх, улирлын мэдээ, тайланг гаргаж ирүүлдэг эсэх болон сургалтын байгууллагын сүүлийн 2 жилийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг тусгана)

7.1.13. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах үлгэрчилсэн хөтөлбөрийг үндэс болгон тухайн ажил мэргэжлийн аюулгүй ажиллагааны онцлогийг тусгасан сургалтын төлөвлөгөө, түүний гүйцэтгэл;

7.1.14. Үйл ажиллагааны дэлгэрэнгүй танилцуулга. (байгууллагын үйл ажиллагаатай холбогдолтой мэдээлэл, фото зураг, сүүлийн 2 жилийн сургалтын үйл ажиллагааны талаарх тайланг хавсаргах).

7.2. Сургалтын байгууллагууд дээр дурдсан баримт бичгийг хуудас бүрээр дугаарлаж, хавтаслан битүүмжилж ирүүлнэ.

НАЙМ. Үнэлэх аргачлал

8.1. Сургалтын байгууллагыг байгууллага бүрээр дор дурдсанаар үнэлнэ:

8.1.1. Ажлын хэсгийн гишүүн бүр сонгон шалгаруулалтын нээлтийн үед бүртгэгдсэн баримт бичигтэй нэг бүрчлэн танилцаж, “Үнэлгээний хуудас”-аар 0-10 хүртэл оноогоор дүгнэнэ.


8.1.2. Сонгон шалгаруулалтын нийт оноо 100 байна. Сургалтын байгууллага нь нийт онооны 75 ба түүнээс дээш хувийг авсан тохиолдолд сонгон шалгаруулалтад “тэнцсэн” гэж үнэлнэ.

8.1.3. Нийт авсан онооны жагсаалтын дарааллаар сургалтын байгууллагуудыг шалгаруулна.

8.1.4. Ажлын хэсгийн гишүүд “Үнэлгээний хуудас”-нд нийт оноог тооцон “Дүгнэлт хэсэг”-т тэнцсэн эсэх талаар тэмдэглэл хийж, гарын үсэг зурж баталгаажуулна.

8.1.5. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь гишүүдийн “Үнэлгээний хуудас”-ыг үндэслэн оролцогчдын жагсаалтыг гаргаж, сонгон шалгаруулалтад “Тэнцсэн”, “Тэнцээгүй” байгууллагуудын дүнг Ажлын хэсгийн дарга, гишүүдэд танилцуулна.

8.1.6. Ажлын хэсэг “Тэнцсэн” оролцогчдыг “Үнэлгээний хуудас”-аар авсан нийт онооны дарааллаар шалгаруулж, Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн дүгнэлт гаргана.






8.1.7. Ажлын хэсгийг гишүүдийн 75 ба түүнээс дээш хувийн ирц бүрдсэн тохиолдолд хуралдуулна. Хурлыг Ажлын хэсгийн дарга удирдана.

ЕС. Бусад зүйл

9.1. Сургалтын байгууллага нь сонгон шалгаруулалтын дүнгийн тухай шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газарт гомдол, маргаанаа бичгээр гаргана.

9.2. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар нь гомдол, маргааныг хүлээн авснаас хойш 14 хоногийн хугацаанд шийдвэрлэж, хариуг албан бичгээр хүргүүлнэ.

9.3. Сургалтын байгууллагын сургалт зохион байгуулах үйл ажиллагаанд харьяалах Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар (хэлтэс)-тай хамтран хяналт тавьж ажиллана.



---oOo---